


ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН

2022-2024 он



ОРШИЛ

Монголын бага насны хүүхдийн хөгжлийн сүлжээ нь 2022 онд Лоринэт Сан болон НҮБ-ын Хүүхдийн Сангийн хамтын санаачилгаар Боловсролын яамны (хуучнаар Боловсрол, шинжлэх ухааны яам) дэмжлэгтэйгээр үүсгэн байгуулагдсан. Уг сүлжээ нь Монгол Улсад бага насны хүүхдийн хөгжлийг дэмжих зорилготой гол оролцогч талуудын харилцаа холбоог сайжруулах, хамтын ажиллагааг дэмжин, улмаар урт хугацаандаа салбар дундын уялдаа холбоо бүхий тогтолцоог бэхжүүлэх зорилготой. Түүнчлэн бага насны хүүхдийн цогц хөгжлийн ач холбогдлыг олон нийтэд таниулах, бодлого боловсруулалтад талуудын оролцоог нэмэгдүүлэх, мэдлэг, мэдээллийг хуваалцах чиглэлээр үйл ажиллагаа явуулж байна.

Энэхүү тайлангаар сүлжээг үүсгэн байгуулагдсанаас хойш хэрэгжүүлсэн ажлын явц болон цаашдын үйл ажиллагааны чиглэлийг хуваалцахыг зорилоо. Сүлжээ үүсгэн байгуулагдсанаас хойш гаргасан ахиц дэвшил, сургамжууд нь Монгол Улсад бага насны хүүхдийн сайн сайхан байдлыг цогцоор дэмжихэд уялдаа холбоо бүхий олон талт хамтын ажиллагаа нэн чухал болохыг харуулсаар байна.

Лоринэт Сан нь Монгол Улсын бага насны хүүхдийн хөгжилд урт хугацааны, тогтвортой үр нөлөөг бий болгохын төлөө зорьж ажилладаг байгууллагын хувьд сүлжээний ахиц дэвшил, гишүүдийн идэвх оролцооноос урам авч цаашид ч мөн оролцогч талуудын хамтын ажиллагааг бэхжүүлэх, нэгдмэл зорилгоор ажиллах ээлтэй орчныг бүрдүүлэхэд хувь нэмрээ оруулсаар байх болно.

© 2025 Лоринэт сан.

Бүх эрх хуулиар хамгаалагдсан болно.

www.lorinetfoundation.org цахим хуудсанд байршуулав.

Холбогдох и-мэйл хаяг: info@lorinetfoundation.org.

ЛОРИНЭТ САНГИЙН ТУХАЙ

Лоринэт сан нь Монгол Улсад туслалцаа дэмжлэг шаардлагатай хүүхэд, залуус, айл өрхүүдийн амьдралд тогтвортой, эерэг өөрчлөлтийг бий болгох үндсэн зорилготой. Бид нийгмийн үр нөлөөг бодитоор авчирч буй шинэлэг төсөл хөтөлбөр хэрэгжүүлэгч байгууллагуудад санхүүгийн болон санхүүгийн бус дэмжлэг үзүүлэх замаар нийгмийн эерэг нөлөөллийг бий болгон ажиллаж байна.



ТАЛАРХАЛ

Лоринэт сангийн зүгээс Монголын бага насны хүүхдийн хөгжлийн сүлжээг хамтран үүсгэн байгуулсан НҮБ-ын Хүүхдийн Сан болон Боловсролын яаманд гүн талархал илэрхийлж байна. Тэдний манлайлал, хамтын ажиллагаа сүлжээг үүсгэн байгуулж, дэмжин чиглүүлэхэд үнэтэй хувь нэмэр оруулсан билээ.

Мөн сүлжээний үйл ажиллагаанд идэвхтэй оролцож хамтран ажилласан бүх гишүүддээ талархал илэрхийлье. Гишүүдийн бүрэн танилцуулгыг "Сүлжээний гишүүд" хэсгээс харах боломжтой. Цаашлаад сүлжээний Удирдах хороо болон Ажлын албаны гишүүд болох Боловсролын хамтын ажиллагааны нийгэмлэг, Монгол Контент ХХК, Монгол Улсын Багшийн их сургуулийн Сургуулийн өмнөх боловсролын сургууль болон Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны (хуучнаар Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам) тууштай дэмжлэг, хамтын ажиллагаанд тусгайлан талархал илэрхийлье.

Түүнчлэн Ази, Номхон далайн орнуудын бага насны хүүхдийн сүлжээ (APNEK), Нэтуорк Импакт байгууллага, Бага насны хүүхдийн бүс нутгийн сүлжээний санд Монголын бага насны хүүхдийн хөгжлийн сүлжээний чадавхыг бэхжүүлэхэд оруулсан хувь нэмэр, дэмжлэгт талархаж буйг илэрхийлэх нь зүйтэй.



ТОВЧИЛСОН ҮГСИЙН ЖАГСААЛТ

АРНЕК – Ази, Номхон далайн орнуудын бага насны хүүхдийн хөгжлийн сүлжээ
(Asia-Pacific Regional Network for Early Childhood)

ГБХНХЯ – Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам

КНХС – Кристина Ноблийн Хүүхдийн Сан

МУБИС – Нэгдсэн Үндэстний Байгууллага

НҮБ – Mongolian Early Childhood Development Network

ОУБ – Олон улсын байгууллага

ОУТББ – Олон улсын төрийн бус байгууллага

ТББ – Төрийн бус байгууллага

ХХК – Хязгаарлагдмал хариуцлагатай компани

АГУУЛГА

1. ХУРААНГУЙ

7

2. ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТОЙМ

9

3. ОНЦЛОХ ҮЙЛ ЯВДЛУУД

11

4. СҮЛЖЭЭНИЙ ҮР НӨЛӨӨ

13

5. ЦААШДЫН АЛХМУУД

17

6. СҮЛЖЭЭНИЙ ГИШҮҮД

18



1. ХУРААНГУЙ

Аливаа улс оронд бага насны хүүхдийн цогц хөгжлийг дэмжихэд салбар дундын хамтын ажиллагаа зайлшгүй шаардлагатай байдаг тул үүнийг бүрдүүлэх хамгийн оновчтой арга нь сүлжээ билээ. Сүлжээ нь оролцогч талуудыг холбон нэгтгэх, харилцан суралцах боломжийг бүрдүүлэх, хамтын ажиллагааг өргөжүүлэх чухал дэд бүтцийг бий болгодог.

Монгол Улсад бага насны хүүхдийн хөгжлийг дэмжин ажилладаг гол оролцогч талуудын уялдаа холбоо дутмаг байдал нь мэдлэг, туршлага хуваалцах боломжийг хязгаарлаж, үйл ажиллагааны давхардлыг бий болгон, хамтын ажиллагаанд хүндрэл учруулдаг байв. Үүнийг шийдвэрлэх зорилгоор Лоринэт Сан НҮБ-ын Хүүхдийн Сантай хамтран, Боловсролын яамны дэмжлэгтэйгээр 2022 онд Монголын бага насны хүүхдийн хөгжлийн сүлжээг үүсгэн байгуулсан юм.

ЗОРИЛГО

Монгол Улсад бага насны хүүхдийн цогц хөгжлийн чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг оролцогч талуудыг холбон нэгтгэх, салбар хоорондын уялдаа холбоог сайжруулах, хамтын ажиллагааг өргөжүүлэх зорилготой.

ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮНДСЭН ЧИГЛЭЛҮҮД

- **Хамтран суралцах:** Гишүүд хоорондын мэдлэг, туршлага солилцох, хамтын ажиллагааг дэмжих, чадавхыг бэхжүүлэх.
- **Олон нийтийн ойлголтыг нэмэгдүүлэх:** Бага насны хүүхдийн цогц хөгжлийн ач холбогдлыг олон нийтэд, ялангуяа эцэг эх, асран хамгаалагчдад сурталчлан таниулах.
- **Бодлого боловсруулалтад оролцох:** Холбогдох бодлогын баримт бичгийн боловсруулалт, хэрэгжилтийн явцад гишүүдийн оролцоог нэмэгдүүлэх.
- **Мэдлэг мэдээллийг түгээх:** Холбогдох мэдлэг, мэдээллийг боловсруулан түгээж оролцогч талуудад нотолгоонд суурилсан шийдвэр гаргахад дэмжлэг үзүүлэх.

Монголын бага насны хүүхдийн хөгжлийн сүлжээ нь үүсгэн байгуулагдсанаасаа хойш эрчимтэй өргөжин тэлж, өдгөө хүүхэд хамгаалал, боловсрол, хоол тэжээл, эрүүл мэндийн чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг 30 гаруй байгууллагыг эгнээндээ нэгтгээд байна. Эдгээр гишүүдэд төрийн байгууллага, хувийн хэвшил, иргэний нийгмийн байгууллага, боловсрол, эрдэм шинжилгээний байгууллага болон хөгжлийн түншүүдийн төлөөлөл багтаж байгаа нь сүлжээг салбар дундын хамтын ажиллагааны нэгдсэн платформ болж буйг харуулж байна.

2022–2024 он буюу сүлжээний эхэн үе шатанд бид үндсэн үйл ажиллагааг хэрэгжүүлэхийн зэрэгцээ засаглалыг бэхжүүлэх, цаашдын хөгжлийн чиглэлийг тодорхойлох зорилгоор олон ажлыг санаачлан хэрэгжүүлсэн.

Гишүүдийн хувьд сүлжээ нь мэдлэг, мэдээлэл солилцох, хамтын ажиллагаа өрнүүлэх гол гүүр болдог. Иймээс оролцогч талуудыг холбон нэгтгэх, сайн туршлага түгээн хуваалцах, хамтын ажиллагааг өргөжүүлэхэд сүлжээний оруулж буй хувь нэмрийг гишүүд онцолсоор ирсэн.

Харин тогтолцооны түвшинд төрийн байгууллагуудтай хамтран бага насны хүүхдийн цогц хөгжлийн томоохон бодлогын баримт бичгийг тодорхойлоход хувь нэмрээ оруулсан билээ. Түүнчлэн холбогдох яамдын дунд байгуулагдсан Бага насны хүүхдийн цогц хөгжлийн орон тооны бус зөвлөлтэй хамтран ажилласан явдал нь сүлжээний ач холбогдлыг оролцогч талууд улам бүр ойлгон хүлээн зөвшөөрч байгаагийн тод илрэл болсон юм.

2024 оны 11-р сард Удирдах хороо болон Ажлын алба байгуулагдсан нь сүлжээний хувьд томоохон ахиц байлаа. Энэхүү үйл явдал нь 2025–2026 онд сүлжээний үйл ажиллагааг тогтворжуулах суурийг тавьсан бөгөөд цаашид гишүүдийн хамтын оролцоо, хариуцлагад суурилсан засаглалыг бий болгоход чиглэх юм.

2. ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТОЙМ

ХАМТРАН СУРАЛЦАХ

- 12 удаагийн улирлын уулзалт зохион байгуулав:
 - 7 удаагийн туршлага солилцох айлчлал
 - 3 удаагийн чадавхжуулах сургалт
 - 2 удаагийн бодлогын хэлэлцүүлэг
- Улирал тутмын цахим товхимлууд болон цахим сувгуудыг эхлүүлэв

БОДЛОГО БОЛОВСРУУЛАЛТАД ОРОЛЦОХ

- Сэдэвчилсэн бодлогын хэлэлцүүлэг зохион байгуулав:
 - Бага насны хүүхдийн цогц хөгжлийг дэмжих арга хэмжээ
 - Хүүхэд харах үйлчилгээний тухай хууль
- Сүлжээний ажлыг Бага насны хүүхдийн цогц хөгжлийн орон тооны бүс зөвлөлд танилцуулав
- Бага насны хүүхдийн хөгжлийн үндэсний чуулга уулзалтыг хамтран зохион байгуулав

+30
ГИШҮҮД

- Хөгжлийн түншүүд
- Дотоодын болон олон улсын ТББ-ууд
- Төрийн байгууллагууд
- Хувийн хэвшлийн төлөөлөл
- Боловсрол, эрдэм шинжилгээний байгууллагууд

ОЛОН НИЙТИЙН ОЙЛГОЛТЫГ НЭМЭГДҮҮЛЭХ

- Бага насны хүүхдийн цогц хөгжлийн талаарх сошиал медиа хуудсыг эхлүүлэв
 - 50+ зурагт контент боловсруулж
 - 2.4 мянга гаруй дагагчтай болж, 205 мянга гаруй хүнд хүрч, 10 мянга гаруй хандалт авсан байна

СҮЛЖЭЭГ БЭХЖҮҮЛЭХ

- Бага насны хүүхдийн бүс нутгийн сүлжээний сангийн санхүүжилтээр Ази, Номхон далайн орнуудын бага насны хүүхдийн сүлжээ (АРНЕК)-аас зохион байгуулсан чадавхжуулах сургалтад оролцов
- Гишүүдийн хэрэгцээ, сүлжээний нөхцөл байдлыг үнэлэх судалгааг зохион байгуулав
- Удирдах хороо болон Ажлын албыг амжилттай үүсгэн байгуулав



3. ОНЦЛОХ ҮЙЛ ЯВДЛУУД

2022 оны 1-2 сар – Сүлжээг үүсгэн байгуулах талаар Лоринэт Сан, НҮБ-ийн Хүүхдийн Сан, Боловсролын яам хоорондын уулзалтуудыг зохион байгуулав

2022 оны 8 сар – Эцэг эх, асран хамгаалагчид болон бага насны хүүхдүүдэд зориулсан хөтөлбөрүүд дээр туршлага солилцох айлчлал хийв (Уанскай ОУБ, Боловсролын Хамтын Ажиллагааны Нийгэмлэг)

2023 оны 5 сар – Бага насны хүүхдийн хөгжлийн үндэсний чуулга уулзалтын үеэр сүлжээний нээлтийн үйл ажиллагааг албан ёсоор зохион байгуулав

2022 оны 3 сар – Сүлжээний чиглэл, үндсэн үүргийг тодорхойлох бүх гишүүдийн анхны уулзалтыг зохион байгуулав

2022 оны 10 сар – Бага насны хүүхдийн цогц хөгжлийг дэмжих бодлогын хэлэлцүүлэгт оролцов

2023 оны 8-10 сар – Бага насны хүүхдийн хөгжлийг дэмжих үндэсний сүлжээг хэрхэн бэхжүүлэх тухай чадавхжуулах сургалтад оролцов (АРНЕК)

2023 оны 9 сар – Олон нийтэд түшиглэсэн бага насны хүүхдийн хөгжлийг дэмжих төвд туршлага солилцох айлчлал хийв

2024 оны 4 сар – Сургуулийн өмнөх боловсролын сургуульд туршлага солилцох айлчлал хийв

2024 оны 9 сар – Кристина Ноблийн Хүүхдийн Сан болон Вэлүү Сангийн хөтөлбөрүүд дээр туршлага солилцох айлчлал хийв

2024 оны 12-р сар – Бүх гишүүд саналаар сүлжээний Удирдамжийг батлав

2023 оны 11 сар – Хүүхэд харах үйлчилгээний тухай хуулийн шинэчилсэн найруулгын хэлэлцүүлэгт оролцов

2024 оны 6 сар – Гүүд Нэйборс ОУТББ-д туршлага солилцох айлчлал хийж, "Хүнс тэжээл" болон "Дизайн сэтгэлгээ" сэдэвт чадавхжуулах сургалтууд зохион байгуулав

2024 оны 11 сар – Шинээр байгуулагдсан Удирдах хорооны анхны хурал болов

4. СҮЛЖЭЭНИЙ ҮР НӨЛӨӨ

4.1. ГИШҮҮДЭД ҮЗҮҮЛСЭН ҮР НӨЛӨӨ

Монголын бага насны хүүхдийн цогц хөгжлийн орон зайд үзүүлж буй сүлжээний үр нөлөөг салбарын гол оролцогч талуудын тууштай идэвх оролцооноос харж болно. Сүлжээ нь нэгдмэл орон зайг бий болгосноор гишүүдэд мэдлэг туршлага солилцох боломжийг олгож, салбар дундын хамтын ажиллагааг дэмжих гүүр болж буйг гишүүдээс авсан судалгааны үр дүн онцолсон билээ.

Харилцан суралцаж бодит үр дүнг авчрах:

Бид бусдаас суралцах зорилгоор сүлжээнд элссэн. Үүний нэг үр дүн бол сүлжээний гишүүн Уанскай ОУБ-ын тоглоомын хэрэглэгдэхүүнийг хөтөлбөртөө оруулснаар бид 20,000 ам.долларын төслийн санхүүжилт авч чадсан явдал юм.
– Дэлхийн Зөн Монгол ОУБ

Үйл ажиллагааны чанарыг сайжруулах:

Хэрэгжүүлж буй үйл ажиллагааныхаа мэдээ, мэдээллийг бусад байгууллагуудтай хуваалцах, хамтын ажиллагаагаа өргөжүүлэх, үйл ажиллагааны чанар хүртээмжийг нэмэгдүүлэх боломж нээгдэж байна.
– Гүүд Нэйборс ОУТББ

Үйлчилгээ үзүүлэгч байгууллагыг төртэй холбох:

Стратегийн ач холбогдолтой мэдээ мэдээллийг авах боломжийг олгодог. Мөн газар дээр үйлчилгээ үзүүлэгч байгууллагыг төртэй холбож санал бодлоо хуваалцаж, аливаа бэрхшээлийг илүү үр дүнтэйгээр шийдвэрлэх боломжийг олгож байна. – Кристина Ноблийн Хүүхдийн Сан

Нэгдсэн мэдээлэл авах:

Бага насны хүүхдийн цогц хөгжлийн талаар системтэйгээр мэдээлэлтэй болж байгаа. Туршлага солилцох айлчлал хийдэг нь хувийн хэвшлийн бидэнд их содон боломж байдаг. “Хамтдаа Уншицгаая” хөтөлбөр дээр айлчлал хийсний дараа бид тус хөтөлбөрт дэмжлэг үзүүлэхээр шийдсэн. – Монгол Контент ХХК

Айлчлалаар дамжуулж туршлага судлах:

Сүлжээний айлчлалууд нь бодит туршлага судлах боломж болдог. Манай Гэр бүлийн төвд хийсэн айлчлалын дараа НҮБ-ын Хүүхдийн Сангаас биднийг туршилтын төсөлд хамтран ажиллахыг урьж мөн манай төвийн загварыг ижил төрлийн олон нийтийн төв байгуулахад жишиг болгон ашигласан. – Уанскай ОУБ

Эрдэм шинжилгээний судалгааг дэмжих:

Сүлжээний тусламжтай манай сургуулийн магистрын хөтөлбөрийн оюутнууд “Хамтдаа Уншицгаая” хөтөлбөрийн суурь судалгааны дата, үр дүнг өөрсдийн судалгааны ажилдаа ашигласан.
– МУБИС-ийн Сургуулийн өмнөх боловсролын сургууль

Гишүүд хоорондын чадавх бэхжүүлэх:

Айлчлалууд болон сүлжээний бусад ажлаар бид Уанскай ОУБ-тай албан ёсны түншлэл байгуулсан. Үүний хүрээнд манай цэцэрлэгийн ажилтан, багш нар бага насны хүүхдийн хөгжлийг дэмжих сургалтад хамрагдаж багшлах арга зүйгээ сайжруулахад тусалсан.
– Вэлүү сан болон Кристина Ноблийн Хүүхдийн Сан

Хамтдаа суралцан хөгжих:

Сүлжээ хөгжихийн тулд гишүүн бүр идэвхтэй хувь нэмрээ оруулж, хамтран ажиллах ёстой. Гэр Өргөө ТББ-ийн зүгээс бид өөрсдийн дизайн сэтгэлгээний ур чадвараа ашиглан сүлжээний лого, брэндийг боловсруулахад тусалж, дизайн сэтгэлгээний талаар сургалтаа гишүүдэд зохион байгуулсан.
– Гэр Өргөө ТББ

4.2. БУСАД ҮР НӨЛӨӨ

4.2.1. БОДЛОГЫН НӨЛӨӨЛӨЛ БА ХАМТЫН АЖИЛЛАГАА

Сүлжээг амжилттай үүсгэн байгуулахад Боловсролын яамны дэмжлэг, хамтын ажиллагаа чухал үүрэг гүйцэтгэж, салбарын гол оролцогч талуудын оролцоог хангаж чадсан билээ. Мөн бага насны хүүхдийн цогц хөгжлийг дэмжих арга хэмжээг шинэчлэн боловсруулахад хувь нэмрээ оруулах боломжийг олгосноор сүлжээний гишүүд өөрсдийн санал зөвлөмжийг хуваалцаж, улмаар 2023 онд уг бодлогын баримт бичгийг Засгийн газраас албан ёсоор баталсан юм.

Сүлжээний үйл ажиллагааг илүү өргөн хүрээнд таниулах үүднээс Боловсролын яамнаас “Бага насны хүүхдийн цогц хөгжлийн үндэсний чуулга” уулзалтын үеэр сүлжээний нээлтийн арга хэмжээг албан ёсоор зохион байгуулсан. Засгийн газрын агентлагууд хамтран хэрэгжүүлсэн уг арга хэмжээнд 21 аймгийн төрийн албан хаагчид болон үйлчилгээ үзүүлэгчид оролцож, сүлжээг үндэсний хэмжээнд таниулах боломж бүрдсэн юм.

Бага насны хүүхдийн цогц хөгжлийн олон талт онцлогийг харгалзан Боловсролын яам нь Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам (ГБХНХЯ) болон бусад голлох оролцогч талуудтай холбон зуучилж, тэдний оролцоог мөн хангаж ажилласан. Үүний үр дүнд ГБХНХЯ-наас сүлжээний үйл ажиллагаанд идэвхтэй нэгдэж, гишүүдийг “Хүүхэд харах үйлчилгээний тухай” хуулийн шинэчилсэн найруулгад саналаа өгөхийг уриалсан нь бодлогын түвшинд гишүүдийн дуу хоолойг тусгах чухал боломжийг бүрдүүлсэн юм.

Цаашлаад сүлжээ нь боловсрол, эрүүл мэнд, нийгмийн хамгааллын яамдын хамтын ажиллагаагаар шинээр байгуулагдсан “Бага насны хүүхдийн цогц хөгжлийн орон тооны бус зөвлөл”-д уригдсанаар цар хүрээгээ улам тэлэв. Энэхүү оролцоо нь зөвлөлийн тэргүүлэх чиглэлүүдтэй уялдаатай ажиллах, цаашдын хамтын ажиллагааны бат бөх суурийг тавьсан чухал алхам болсон билээ.

4.2.2. ОЛОН НИЙТИЙН НӨЛӨӨЛӨЛ

Бага насны хүүхдийн цогц хөгжлийн ач холбогдлыг олон нийтэд, ялангуяа эцэг эх, асран хамгаалагчдад сурталчлан таниулах шаардлагыг сүлжээний гишүүд тогтмол онцолж ирсэн. Олон нийтийн ойлголтыг нэмэгдүүлэх нь нийгэм, соёлын зөрөг өөрчлөлтийг бий болгоход чухал ач холбогдолтой учраас бид үүнийг сүлжээний үйл ажиллагааны үндсэн чиглэлийн нэг болгон анхаарч ажиллаж байна.

Үүний хүрээнд гишүүн байгууллага Монгол Контент ХХК-тай хамтран монгол хэл дээрх сэдэвчилсэн контент бүхий сошиал медиа хуудсыг эхлүүлсэн. Энэхүү дижитал эх сурвалжийг ашиглан Лоринэт Сан, НҮБ-ийн Хүүхдийн Сан болон Боловсролын яамнаас эцэг эх, асран хамгаалагчид, багш нар, 21 аймгийн төрийн албан хаагчдад өргөнөөр хүргэж, төрөл бүрийн сэдэвчилсэн арга хэмжээнд идэвхтэй сурталчлан таниуллаа.

4.3. СҮЛЖЭЭГ БЭХЖҮҮЛЭХ

Лоринэт Сан болон НҮБ-ийн Хүүхдийн Сангаас сүлжээний үндсэн үйл ажиллагааг манлайлан хэрэгжүүлэхийн зэрэгцээ чадавхыг нэмэгдүүлэх, засаглалыг бэхжүүлэхэд тогтмол анхаарч тууштай хүчин чармайлт гаргасаар ирсэн.

- **Гишүүдийн хүрээг тэлэх:** Эрүүл мэндийн салбар, багшийн мэргэжил дээшлүүлэх байгууллагууд болон орон нутгийн ТББ-уудаас шинэ гишүүдийг татан оролцуулж, илүү өргөн хүрээний төлөөллийг бүрдүүлэн гишүүдийн идэвхтэй оролцоог нэмэгдүүлэв.
- **Сүлжээний хөгжилд чиглэсэн чадавхжуулах сургалт:** АРНЕК-аас боловсруулж Нэтуорк Импакт байгууллагаас зохион байгуулсан бага насны хүүхдийн хөгжлийн үндэсний сүлжээг бэхжүүлэх тухай 3 сарын сургалтад амжилттай хамрагдсан. Тус сургалтыг Бага насны хүүхдийн бүс нутгийн сүлжээний сан (ECRNF)-аас санхүүжүүлсэн. Сургалтаар сүлжээний өсөлтийн үе шат, стратегийн төлөвлөлт, үнэлгээний хэрэгслийн талаар цогц мэдлэгийг олж авсан бөгөөд эдгээрийг ашиглан сүлжээний хэрэгцээ, шаардлагыг илүү нарийн тодорхойлох, үр дүнтэй байдлыг үнэлэх судалгааг хэрэгжүүлсэн юм.
- **Засаглалыг бэхжүүлэх:** Сүлжээний удирдамжийг илүү боловсронгуй болгож, хамтын ажиллагаа болон тогтвортой байдлыг гүнзгийрүүлэн хэлэлцэхээр сүлжээний гишүүдтэй уулзалтуудыг зохион байгуулсан. Үүний үр дүнд 2024 оны 11-р ард сүлжээний Удирдах хороо болон Ажлын албыг амжилттай томилсон юм.

5. ЦААШДЫН АЛХМУУД

Сүлжээний эхэн үеийн ололт амжилт дээр тулгуурлан цаашид үйл ажиллагааг тогтворжуулах, засаглалыг бэхжүүлэхэд анхаарч ажиллана. Сүлжээг хамтран санаачилсан Лоринэт Сан болон НҮБ-ийн Хүүхдийн Сангаас үргэлжлүүлэн сүлжээг манлайлан ажиллах хэдий ч, Удирдах хороог үүсгэн байгуулсан явдал нь цаашид гишүүдийн хамтын оролцоо, хариуцлагад суурилсан засаглалыг хөгжүүлэх ээлтэй орчныг бүрдүүлнэ хэмээн итгэж байна.

2025-2026 ОНЫ ТӨЛӨВЛӨГӨӨ:

➔ ХАМТРАН СУРАЛЦАХ

- Гишүүнчлэлийн хүрээг тэлж, орон нутгаас болон хангалттай төлөөлөлгүй байгаа салбаруудаас шинэ гишүүдийг элсүүлэх.
- Харилцаа холбоо тогтоох, мэдлэг туршлагаа хуваалцах, чадавх бэхжүүлэхэд үр дүнтэй стратеги боловсруулан хэрэгжүүлэх

➔ ОЛОН НИЙТИЙН ОЙЛГОЛТЫГ НЭМЭГДҮҮЛЭХ

- Эцэг эх, асран хамгаалагчид болон үйлчилгээ үзүүлэгчдэд зориулан бага насны хүүхдийн хөгжлийн талаарх мэдлэг, ойлголтыг нэмэгдүүлэх үр дүнтэй арга барилыг боловсруулж, хэрэгжүүлэх.

➔ БОЛОВСРУУЛАЛТАД ОРОЛЦОХ

- Бага насны хүүхдийн цогц хөгжлийн орон тооны бус зөвлөлтэй хамтран ажиллах
- Үйлчилгээ үзүүлэгч байгууллагуудыг бодлого боловсруулагчидтай холбох

➔ МЭДЛЭГ, МЭДЭЭЛЛИЙГ ТҮГЭЭХ

- Салбарын оролцогч талуудад мэдлэг мэдээллийг түгээж оновчтой, нотолгоонд суурилсан шийдвэр гаргалтыг дэмжих



6. СҮЛЖЭЭНИЙ ГИШҮҮД

УДИРДАХ ХОРОО



ТӨРИЙН БАЙГУУЛЛАГУУД



ОЛОН УЛСЫН БАЙГУУЛЛАГУУД



ДОТООДЫН ТӨРИЙН БУС, ЭРДЭМ ШИНЖИЛГЭЭ, ХУВИЙН ХЭВШЛИЙН БАЙГУУЛЛАГУУД

